ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Мянган жаргалан Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2023/101/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn

Аудитор М.Нурболат

Утас: 9902-7275, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 8
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 9
4.1 Ерөнхий зүйл ........ 9
4.2 Материаллаг байдал ........ 10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 11
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 11
5.1 Зөвлөмж ........ 11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 269

танай ____________-ны №______________-т

ХЭРЛЭН СУМЫН МЯНГАН ЖАРГАЛАН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА М.САРУУЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын Мянган жаргалан өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын Мянган жаргалан өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0110?0376

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 324,863,636.28 | 255,697,497.74 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 27,890,871.23 | 26,773.70 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | - | 0.25 |
| 31110 | Төгрөг | - | 0.25 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 27,890,871.23 | 26,773.45 |
| 3121 | Төгрөг | 27,890,871.23 | 26,773.45 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 27,890,871.23 | 26,773.45 |
| 33 | АВЛАГА | 184,914,000.00 | 3.78 |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 184,914,000.00 | 2.84 |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | - | 0.94 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 112,058,765.05 | 255,670,720.26 |
| 351 | Түүхий эд материал | 48,390,622.05 | 151,747,612.26 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 48,390,622.05 | 151,747,612.26 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,697,606.00 | 9,658,329.00 |
| 354 | Хангамжийн материал | 61,970,537.00 | 94,264,779.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,763,550.00 | 125,993.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 59,206,987.00 | 94,138,786.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 266,664,383.98 | 323,586,390.51 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 266,664,383.98 | 323,586,390.51 |
| 391 | Газар | 6,900,000.00 | 6,900,000.00 |
| 392 | Биет хөрөнгө | 249,209,019.25 | 306,700,187.59 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 224,422,295.95 | 224,422,295.95 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (19,610,498.66) | (23,294,731.31) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 27,900,000.00 | 27,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (21,650,000.00) | (23,559,722.22) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 104,247,907.56 | 143,586,535.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (82,413,494.94) | (108,859,041.50) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 49,297,900.00 | 107,992,274.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (32,985,090.67) | (41,487,422.88) |
| 39301 | Програм хангамж | 445,900.00 | 445,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (445,900.00) | (445,900.00) |
| 394 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 10,555,364.74 | 9,986,202.91 |
| 39401 | Биологийн хөрөнгө /ТӨҮГ/ | 12,558,076.16 | 12,558,076.16 |
| 39402 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/ | (2,002,711.42) | (2,571,873.25) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 591,528,020.26 | 579,283,888.24 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 390.38 | 0.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 390.38 | 0.00 |
| 413 | Өглөг | 390.38 | 0.00 |
| 4136 | Бусад өглөг | 390.38 | 0.00 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 389.50 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 591,527,629.88 | 579,283,888.24 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 591,527,629.88 | 579,283,888.24 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 299,047,476.66 | 299,047,476.66 |
| 51101 | Өмч: - төрийн | 299,047,476.66 | 299,047,476.66 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 204,752,844.33 | 192,509,102.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 38,667,605.97 | 204,752,844.33 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 166,085,238.36 | (12,243,741.64) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 87,727,308.89 | 87,727,308.89 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 591,528,020.26 | 579,283,888.24 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,787,268,637.22 | 1,059,640,518.85 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 769,626,187.22 | 1,059,640,518.85 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 769,626,187.22 | 1,059,640,518.85 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 919,709,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 919,709,000.00 |
| 120009 | Бусад орлого | 769,626,187.22 | 139,931,518.85 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,017,642,450.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 395,442,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 395,442,900.00 | |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 622,199,550.00 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 622,199,550.00 | |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,621,183,398.86 | 1,071,884,260.49 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,564,819,149.86 | 1,071,884,260.49 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,564,819,149.86 | 1,061,324,260.49 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 379,232,767.00 | 530,850,946.00 |
| 210101 | Үндсэн цалин | 379,232,767.00 | 530,715,946.00 |
| 210104 | Урамшуулал | - | 135,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 44,493,055.44 | 65,391,533.38 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 44,493,055.44 | 65,391,533.38 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,234,048.39 | 10,630,375.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,709,047.39 | 8,314,707.25 |
| 210304 | Байрны түрээс | 2,525,001.00 | 2,315,668.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 51,180,144.48 | 72,742,149.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 34,794,407.00 | 36,515,691.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,210,180.00 | 1,468,240.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 9,964,657.48 | 26,506,162.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 5,210,900.00 | 8,252,056.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,015,955,698.90 | 312,256,557.79 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,015,955,698.90 | 312,256,557.79 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 3,591,001.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 3,591,001.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 221,444.00 | 202,029.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49,500.00 | 23,936.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,904.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 16,560.00 | 33,293.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 99,480.00 | 144,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,501,991.65 | 65,659,669.08 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 38,042,362.00 | 22,851,553.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 360,000.00 | 1,697,120.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,099,629.65 | 41,110,995.48 |
| 211 | ХҮҮ | - | 10,560,000.00 |
| 2112 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | - | 10,560,000.00 |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | - | 10,560,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 56,364,249.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 56,364,249.00 | - |
| 225101 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/ | 56,364,249.00 | |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 166,085,238.36 | (12,243,741.64) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 166,085,238.36 | (12,243,741.64) |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 857,195,650.00 | 1,108,793,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 24,467,200.00 | 4,170,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 24,467,200.00 | 4,170,000.00 |
| 120009 | Бусад орлого | 24,467,200.00 | 4,170,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 832,728,450.00 | 1,104,623,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 395,442,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 395,442,900.00 | |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 437,285,550.00 | 1,104,623,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 437,285,550.00 | 1,104,623,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 860,948,936.39 | 1,094,977,457.53 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 860,948,936.39 | 1,094,977,457.53 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 860,948,936.39 | 1,094,977,457.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 316,264,941.00 | 392,490,550.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | 316,264,941.00 | 392,490,550.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 83,621,973.00 | 118,704,212.53 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 83,621,973.00 | 118,704,212.53 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,288,353.39 | 35,628,601.25 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 28,288,353.39 | 35,628,601.25 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 399,465,862.50 | 491,922,037.75 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 3,344,700.00 | 4,752,056.00 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 396,121,162.50 | 487,169,981.75 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,307,806.50 | 56,232,056.00 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 31,210,690.00 | 45,060,056.00 |
| 210817 | Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/ | 49,500.00 | - |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 2,047,616.50 | 11,172,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (3,753,286.39) | 13,815,542.47 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | 5,107,344.00 | 17,299,550.00 |
| 140003 | Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт | 5,107,344.00 | 17,299,550.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 10,608,294.00 | 58,979,190.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 10,608,294.00 | 58,979,190.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 10,608,294.00 | 58,979,190.00 |
| 225105 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/ | 10,608,294.00 | 58,979,190.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (5,500,950.00) | (41,679,640.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (9,254,236.39) | (27,864,097.53) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 37,145,107.62 | 27,890,871.23 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 27,890,871.23 | 26,773.70 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 299,047,476.66 | 87,727,308.89 | 38,667,605.97 | 425,442,391.52 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 299,047,476.66 | 87,727,308.89 | 38,667,605.97 | 425,442,391.52 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 166,085,238.36 | 166,085,238.36 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 299,047,476.66 | 87,727,308.89 | 204,752,844.33 | 591,527,629.88 |
| D01 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 299,047,476.66 | 87,727,308.89 | 204,752,844.33 | 591,527,629.88 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 299,047,476.66 | 87,727,308.89 | 204,752,844.33 | 591,527,629.88 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (12,243,741.64) | (12,243,741.64) |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 299,047,476.66 | 87,727,308.89 | 192,509,102.69 | 579,283,888.24 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Мянган жаргалан Өрхийн эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх,хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Зорилго: Эмнэлгийн ажилтны ёс зүйг эрхэмлэн дээдэлж өрх, иргэн бүрт нийгмийн болон эрүүл мэндийн анхан шатны түргэн тусламжийн үйлчилгээг ур чадварын өндөр түвшинд хүртээмжтэй хүргэж, эрүүл аж төрөх зөв дадлыг эзэмшүүлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Мянган жаргалан Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Мянган жаргалан Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12.2 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 27,890.9 | 26.8 | (27,864.1) |
| Авлага | 184,914.0 | 0.0 | (184,914.0) |
| Бараа материал | 112,058.8 | 255,670.7 | 143,612.0 |
| Үндсэн хөрөнгө | 266,664.4 | 323,586.4 | 56,922.0 |
| **Нийт хөрөнгө** | **591,528.0** | **579,283.9** | **(12,244.1)** |
| Өглөг | 0.4 | 0.0 | (0.4) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 591,527.6 | 579,283.9 | (12,243.7) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **591,528.0** | **579,283.9** | **(12,244.1)** |

Авлага 184.9 сая төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал данс 255.7 сая төгрөг болж 143.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой 103.3 сая төгрөгийн түүхий эд материал, 32.3 сая төгрөгийн хангамжийн материал нэмж бэлтгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө 323.6 сая төгрөг болж 56.9 сая төгрөгөөр өссөн нь худалдан авалтаар 98.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, тайлант хугацаанд 41.1 сая төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 579.2 сая төгрөг болж 12.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны алдагдалтай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төслийг нэг иргэнд тооцсон санхүүжилт, тохиолдлоор тооцсон тусламж үйлчилгээний санхүүжилт, байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн төлөвлөсөн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалаас нийт 1,104.6 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 1,094.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Мянган жаргалан Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Мянган жаргалан Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,240.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 18.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2.0 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн бөгөөд бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 2.0 | 1 | 2.0 | 100 |
| **Нийт дүн** | **1** | 2.0 | **1** | 2.0 | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн худалдан авалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг холбогдох хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой алдаа[1] илэрсэн бөгөөд эцсийн үр дүнд нөлөө үзүүлэхгүй тул залруулга гараагүй боловч алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд: 2022 оны гүйцэтгэлээр санхүүжилтийн орлогыг мөнгөн сууриар бүртгэдэг.

### 5.1 Зөвлөмж

***Илрүүлэлт:*** Эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилдэг. Уг нэхэмжлэлийг илгээснээс хянагдаад санхүүжилт орж ирэх хооронд тодорхой хугацаа зарцуулдаг бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт орж ирсэн үед орлогоор хүлээн зөвшөөрдөг байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн:*** Ард иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль, журмын дагуу үзүүлсэн үйлчилгээний дэмжих баримтыг үнэн зөв бэлдэх, нэхэмжлэл гаргахаас өмнө хянах, эцсийн байдлаарх нэхэмжлэлийн нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аккруэл суурийг баримтлан ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЭМТ нь гүйцэтгэлээр санхүүжилтийн орлогыг мөнгөн сууриар бүртгэдэг | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | 1 | - |
| Дүн | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | 1 | - |